



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/587

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 8 дугаар хуралдааны 8/04 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтын 5.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Булган суманд зохион байгуулагдах Баруун бүсийн сумдын хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх практик сургалтын зардалд 2 500 000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 2 500 000 төгрөг /Хоёр сая таван зуун/-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 8 дугаар хуралдааны 8/04 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт "Орон нутгийн Хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалт"-ын 5.3 дахь "Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх" дэд хөтөлбөрөөс гаргахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/587 Ch
02 02915